

**"СУМЫН ТӨВИЙН ШИНЭЧЛЭЛ" ТӨСЛИЙН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ
ДААЛГАВАР /БАЯНХОНГОР, ХҮРЭЭМАРАЛ СУМ/**

2024 оны 07 дүгээр сарын 01-ны өдөр №05 Номгон

1	Үндэслэл	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа - 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хөгжүүлэх үйл ажиллагааны зорилтын 3.6.1; - Баянхонгор Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр;
2	Зорилго	Хүрээмарал сумын төвийн инженерийн шугам сүлжээг сайжруулах, инженерийн дэд бүтцэд холбоно. Тус сумын иргэд эрүүл ахуйн шаардлага хангасан ундны цэвэр усаар хангагдаж, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, ариутгах татуургын шугамд холбогдохын зэрэгцээ төвлөрсөн дулаан хангамжтай, тав тухтай орчинд ажиллаж амьдрах боломж бүрдүүлнэ.
3	Барилга байгууламжийн байршил	Баянхонгор аймаг, Хүрээмарал сум, Дэлгэрмөрөн 5-р баг /Төлөвлөлтийн хязгаар, хамрах хүрээг хавсралт 1 үзэх/
4	Барилга байгууламжийн байршил, инженерийн шугам сүлжээний одоогийн байдал	<p>Газарзүйн байрлал Хүрээмарал сум нь Улаанбаатар хотоос 960 км аймгаас 230 км-т оршдог, хүн амын тоогоор аймагтаа 3-р байранд ордог Баянхонгор аймгийн тал хээрийн бүсийн төв юм.</p> <p>Байршил: Баянхонгор аймаг, Хүрээмарал сум, Дэлгэрмөрөн 5-р багийн нутаг дэвсгэрт</p> <p>Хүн ам: Хүрээмарал сум нь 3578 хүн амтай. / 2021 оны байдлаар/ <u>Хүрээмарал сумын инженерийн хангамжийн одоогийн байдал :</u></p> <p>Цахилгаан хангамж: Өвөрхангай -Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон. 15 кВ-ын ЦДАШ, Хүрээмарал дэд станц 15/04 кВ-ын 160кВТ –ыг 2020 онд ашиглалтад оруулсан.</p> <p>Усан хангамж: Сумын төвд унд ахуйн худгаас зөөврөөр-3, тариалангийн зориулалтаар -2, , эх үүсвэрийн гүний худаг-1 / Итгэл мандал констракшн ХХК-ын халаалтын зуухны хашаанд гүний худаг 1.3 л/сек/. 2020 онд сумын төвийн төрийн өмчийн барилга байгууламжууд дулаан хангамжийн системд холбогдсон бөгөөд дулааны шугамын сувагчлалд цэвэр усны түгээх шугам хамт тавигдсан. Сумын төвийн ус хангамжийн хэрэгцээг хангах усны эх үүсвэрийн хайгуул, шинжилгээ хийх шаардлагатай.</p> <p>Дулаан хангамж: Сумын төвийн дулааны хангамжийг "Итгэлт мандал констракшн" ХХК хариуцан хангадаг. Одоо байгаа халаалтын зуух Экономайзер 1.25 маркийн 1.5МВт хүчин чадалтай 2 тогоо суурилагдсан. Сумын төвийн төрийн өмчийн барилга байгууламжууд дулаан хангамжийн системд холбогдсон</p> <p>Ариутгах татуургын шугам: Сумын төвд одоогоор нэгдсэн ариутгах татуургын систем болон цэвэрлэх байгууламж байхгүй ба 2022 онд ашиглалтад оруулсан 240 хүний суудалтай соёлын төв, 2023 онд ашиглалтад оруулсан 15 ортой эмнэлгийн барилга, Цэцэрлэгийн барилга, сургуулийн дотуур байрны барилгуудын ариутгах татуургын шугам, бохирын цооногууд бий.</p> <p>Холбоо мэдээллийн сүлжээ: Жи-Мобайл, Мобиком, Юнител үүрэн холбооны сүлжээнд холбогдсон. радио, телевизийн 6 суваг, радио, телевиз тоон системд шилжиж шилэн кабелийн шугам тавигдсан.</p>

		<p>2. Инженерийн шугам сүлжээ а. 1500 у/м – гадна дулааны хос шугам, /дулааны сувагт/ сувгийн трасс төлөвлөх/ Хуучин байгаа шугамыг шинэчлэн, өргөтгөх, нэмэгдүүлэх, хэрэглээний халуун усны шугамын хамт төлөвлөх/ б. 1500 у/м гадна ус хангамжийн шугам /дулааны сувагт/ шинэчлэх/ нэмж төлөвлөх/ в. 2500 у/м ариутгах татуургын шугам г. 800 у/м шугам, 15/0.4кВ-ын дэд станц – цэвэрлэх байгууламж болон усан сангийн гадна цахилгааны шугам</p> <p>3. Тохжилт, ногоон байгууламж а. 3000м² – явган зам б. 2000м² – мод, бут сөөг тарих в. 80ш – явган замын гэрэлтүүлэг г. 6ш – амрах саравч /сүүдрэвч/ д. Камержуулалт</p> <p>4. Талбайн тохижилтын ажил-/1/ боломжтой байршлыг судалж, иргэдийн ая тухтай амрах, зугаалах, спортоор хичээллэх орчинг бүрдүүлж төлөвлөх, Хүүхдийн тоглоомын талбайг тусгайлан төлөвлөх</p> <p>5. Авто зам , замын байгууламж 2500м хатуу хучилттай авто зам /өргөн 7м/, ногоон байгууламжийн зурвасын өргөн /норм стандартын дагуу/, явган зам /өргөн 1,5м/, гэрэлтүүлэгтэй /гэрэлтүүлгийн тоо норм стандартын дагуу/ байхаар төлөвлөх.</p>
5	Хэрэглэгчийн ачаалал	<p>Одоо байгаа барилга, байгууламжууд:</p> <ul style="list-style-type: none"> • ЗДТГ, засаг захиргаа • Соёлын төв /шинэ/ • Соёлын төв /хуучин/ • Сургууль, сургуулийн дотуур байр • Цэцэрлэгийн барилга • Эрүүл мэндийн төв, эмнэлэг, амбулатори • Эрүүл мэндийн төв, эмнэлэг, амбулатори /шинэ/ • Цагдаагийн барилга • Халуун усны барилга • Үйлдвэрийн барилга • Сумын төвийн хэсэгт байрлах ахуйн үйлчилгээ, дэлгүүр, цайны газар зочид буудал, халуун ус • Сумын төвийн эхний ээлжийн боломжит айл өрхүүд
6	Зураг төсөл, бүрдэл	<ul style="list-style-type: none"> • Байр зүйн дэвсгэр зураг • Инженер геологийн судалгааны ажлын тайлан /дүгнэлт/ /Ажлын даалгаврыг гүйцэтгэгч нь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай зөвшилцөнө./ • Усны эрэл хайгуулын судалгааны тайлан • Инженерийн байгууламжийн иж бүрэн ажлын зураг: <ul style="list-style-type: none"> • Дулаан хангамж /дулааны гол болон салбар шугам шинэчлэн солих ба хэрэглэгч байгууллагуудын дулааны зангилаа /узельд/-д холболт хийх: • Ус хангамж, ариутгах татуурга: • Цахилгаан хангамж: • Холбоо дохиолол • Үерийн далан суваг <p>/Одоо байгаа барилга байгууламжийг инженерийн шугам сүлжээнд холбох нөхцөл боломжийг судлаж техникийн шийдэл гаргах./</p> <ul style="list-style-type: none"> • Инженерийн байгууламжийн иж бүрэн ажлын зураг: <ul style="list-style-type: none"> • Цэвэрлэх байгууламж, цэвэрлэсэн усыг хэрхэн хадгалах нөөцлөх, дахин ашиглах талаар төлөвлөх: • Цэвэрлэх байгууламжийн хог хаягдал, лагийг хэрхэн боловсруулах: <ul style="list-style-type: none"> • Усан сан /70м³/ • Тохжилт ногоон байгууламжийн ажлын зураг: <ul style="list-style-type: none"> • Явган зам талбай:

		<ul style="list-style-type: none"> • Мод бут сөөг, зүлэгжүүлэлт хийх: • Явган замын гэрэлтүүлэг: • Саравч /сүүдрэвч/ • Спорт талбай • Авто замын ажлын зураг <ul style="list-style-type: none"> • Инженер геодезийн ажлын тайлан, Инженер геологийн судалгааны ажлын тайлан • Авто зам, замын байгууламжийн инженерийн нарийвчилсан зураг төсөл • Зургийн тайлбар бичиг/ус зайлуулах болон инженерийн байгууламжийн тооцоо, хучилтын тооцоо, ажлын нэр, тоо хэмжээ, холбогдох захирамж, техникийн нөхцөлүүд/ • Техникийн шаардлага • Авто замын байгууламжийн нэгдсэн төсөв • Авто зам, замын байгууламжийн зураг төслийн магадлалын ерөнхий дүгнэлт <p><u>Зураг төсөлд тавигдах шаардлага</u></p> <p>-Бүх ажлын зургийг холбогдох байгууллагуудтай зөвшилцөж, батлуулсан байх</p> <p>-Ажлын зураг төслийг норм, дүрэм стандартын дагуу төлөвлөх ба тохижилтын элементүүдийн ерөнхий харагдах байдлыг 3D буюу 3 хэмжээст зураглалаар гүйцэтгэх:</p> <p>-Ажлын зураг төсвийг боловсруулахдаа Хүрээмарал сумын удирдлага, иргэдтэй зөвшилцөх.</p> <p>- Батлагдсан (иж бүрэн ажлын зураг төсөл, төсөв, тайлбар бичиг)-г хэвлэмэл болон файл байдлаар (CD-нд бичиж) 4 хувь бэлтгэж, захиалагчид эх хувь 1, Баянхонгор аймгийн ЗДТГ-т 1, Аймгийн ГХБХБГ-т 1, Хүрээмарал сумын ЗДТГ-т 1 хүлээлгэн өгнө.</p>
7	Ажил гүйцэтгэх хугацаа	Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд хугацааг тодорхой заасан байна. /Гэрээ байгуулснаас хойш ... сарын хугацаанд багтаан гүйцэтгэнэ/
8	Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<p><u>Монгол Улсын хуулиуд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Хот байгуулалтын тухай хууль; Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль; Барилгын тухай хууль; Газрын тухай хууль; Геодези, зураг зүйн тухай; Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай; Байгаль орчныг хамгаалах тухай хууль; Усны тухай хууль; Хот суурин газрын ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль; Эрчим хүчний тухай хууль; Байгаль орчныг хамгаалах тухай; Хөрөнгө оруулалтын тухай; Эрүүл ахуйн тухай; Сэргээгдэх эрчим хүчний тухай; Эрчим хүч хэмнэлтийн тухай; Бусад хууль тогтоомж; <p><u>Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг “Алсын хараа 2050”; - Ногоон хөгжлийн бодлого; - Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр; - Аймгийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр; - Бусад. <p><u>Норм норматив, стандарт:</u></p> <ul style="list-style-type: none"> - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНБД 30-01-04); - Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар (УББ 11-202-00); - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм; - Геодезийн байнгын цэг тэмдэгт байгуулах ажил БД 11-104-06; - 1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил БД 11-106-08;

ХЯНАСАН: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨРЖЛИЙН БОЛГОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ТАНИЦСАН:


Баянхонгор аймгийн Ерөнхий Архитектор

О.ХҮРЭЛХҮҮЯ


БОЛОВСРУУЛСАН:

ХОТ БАЙГУУЛАЛТЫН КАДСТЕР ЭХИЛТ ТӨСӨЛ МАГАДЛАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН


Ө.ХАНДАРМАА



<p>Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зөлтэй орчныг бүрдүүлэх зорилгоор зам талбай болон хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх:</p> <p>Авто замын үндсэн элементүүд болох зорчих хэсэг, явган хүний зам, нийтийн тээвэр болон автомашинч я зосоол, автомашин, явган хүний гарц, ногоон байгууламж, гадаргуугийн услаг зайлуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээг зэргийг хамруулан зургийг иж бүрээр төлөвлөх:</p> <p>Улаваар, хөдөлгөөн зохион байгуулалтыг цогц шинийдвэрлэх Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөний зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байлцаар зураг төсөлд тусгах</p> <p>Авто замын гаралтүүлийг сэрээгдэх эрчим хүчний хэмнэлтэй, чанарын шаардлага хангасан "LED" технологийг шинийдвэрлэх Инженерийн байгууламж шугам сүлжээний ажлын зураг төслийг эх үүсвэр болон хэрэглэгчтэй холбох хүртэл иж бүрэнээр боловсруулах Цэвэрлэсэн услаг дахин ашиглах, хурын услаг хуримтлуулах талаар төлөвлөх</p> <p>Газар хөдлөлтийн нөлөөллийг тооцох</p> <p>Инженер геологийн дүгнэлтийг үндэслэн хөрсний усныг хэлбэлзээс үүсэх эрсдэлийг тооцоолон хамгаалах арга хэмжээг үүдний холбогдох норм, дүрэм, зааврын дагуу төлөвлөх</p> <p>Газар болон дээрх нон хөнгөнөрийн байгууламжтай огтлолцох, давхцах тохиолдолд буцаагч шаардлагатай мөчлөг арга хэмжээг авахаар таарах зардлыг ажлын зураг, хяналтын төсөвт тусгах</p> <p>Шаардлагатай нөхцөл Байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлжээ</p>	<p>Хийлгэх</p>
---	----------------




БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХИЛИЙН ЗУРАГ



Text

ТАНИХ ТЭМДЭГ

-  Төлөвлөлтийн хил /209 га/
-  Суурьшлын бүс /115 га/



Meters

1 centimeter = 100 meters